

БУЛГАН АЙМАГТ 2013-2016 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ “ШАТАР” ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Монгол Улсын биеийн тамир спортын тухай хуулийн 18-р зүйлийн 8, 9, 10 дахь заалтууд, БСШУСайдын 2011 оны 471 тушаал, Булган аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2007 оны 214 тогтоол, Булган аймгийн Засаг даргын 2008 оны 467-р захирамж, шатрын спортыг хөгжүүлэх тухай иргэдийн хүсэлт зэргийг үндэслэл болгон энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Булган аймгийн шатрын спортын хөгжлийн өнөөгийн байдал:

Тус аймгийн тамирчдын амжилт 1970 оны үеэс эхлэн түргэн хугацаанд дээшлэн 1973 онд багийн Улсын аварга шалгаруулах тэмцээнд түрүүлж амжилтын гараагаа эхлүүлснээр Гавьяат багш спортын мастер Д.Ламжав, ОУХМастер Ч.Хүрэлбаатар, Монгол улсын аварга спортын мастер С.Тунгалаг, ОУХМастер Улсын аварга Ө.Гэрэлмаа нарын олон арван тамирчид төрөн гарч олимп, тив, дэлхийн болон улсын аварга шалгаруулах тэмцээнүүдэд амжилт гаргаж байсан уламжлалтай.

1986, 1997 онуудад өсвөр үеийн УАШТэмцээнд багийн дүнгээр “Хүрэл” медаль, 1988 онд насанд хүрэгчдийн Улсын аварга багаар шалгарч, 1989 онд Монгол улсын аварга шалгаруулах тэмцээнийг хөдөө орон нутагт анх удаа зохион байгуулан 1994 онд насанд хүрэгчдийн багийн УАШТ-нд ахин түрүүлж байсан түүхэн амжилттай.

Аймгийн Засаг даргын захирамжаар шатрын “Сөрт” клуб, Шатрын холбоог байгуулан ажилласнаар Хүүхэд багачуудын дунд шатрын спортыг хөгжүүлэхэд ихээхэн ахиц гарсны зэрэгцээ сумдад сургагч багш бэлтгэх сургалтууд хийх, орчин үеийн программууд бүхий компьютерүүдтэй болох, ахмад шатарчдын нэрэмжит тэмцээнүүдийг зохион байгуулах, улс бүсийн чанартай уралдаан тэмцээнүүдэд оролцох, зохион байгуулах ажлууд хийгдэж байна.

Хэдийгээр зохион байгуулалтын ажлууд хийгдэж байгаа боловч хичээллэгч тамирчид, сонирхогчид тодорхой хэмжээний тооноос хэтрэхгүй, ахмад үеийн шатарчдыг залгамжлах өсөх ирээдүйтэй шатарчид төдийлөн олноор төрөхгүй, олон нийтийг бүрэн дүүрэн хамруулах талаар учир дутагдалтай, мэргэжлийн багш дутмаг, төсөв санхүү хүрэлцээгүй, нийтийг хамарсан шатарчдын чөлөөт цагийг өнгөрөөх зориулалтын танхим, гадна задгай талбай байхгүй зэргээс шалтгаалан шатрын спорт хөгжлийн шинэ шатанд хүрэхгүй байна.

Иймд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны “Шинэ Булган” хөтөлбөрт “Шатар” хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр тусгаж аймгаараа шатарчин болох аяныг өрнүүлэх шаардлагатай гэж үзлээ.

Хөтөлбөрийн уриа:

Оюунлаг Булганчууд Шинэ Булганыг бүтээнэ.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Булган аймагт шатрын спортыг эрчимтэй хөгжүүлж, иргэд, байгууллага, хамт олны санал санаачлагыг өрнүүлэх замаар бүх нийтийн спорт болгох, өндөр зэрэгтэй шатарчдыг тусгайлан бэлтгэх, нөхцөл боломжийг бүрдүүлж улсын болон олон улсын тэмцээн уралдаан амжилттай оролцох, төрийн болон төрийн бус байгууллагууд, аж ахуйн нэгж, ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдэд шатрын спортыг хөгжүүлэх өөрийн онцлогт тохирсон хөтөлбөртэй болгох, Насанд хүрэгчдийн ба сурагчдын аймгийн шигшээ багтай болох, эцэг эх байгууллага хамт олны хамтын ажиллагааг сайжруулах, улс, аймгийн тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулах зорилготой.

Гурав. Хөтөлбөрийн зорилт хүрэх үр дүн

3.1 Шатрын спортыг хөгжүүлэхэд удирдлага зохион байгуулалтаар хангах, мэдээ мэдээллээр хангах, санал санаачилгыг дэмжих замаар бүх нийтийн үйл хэрэг болгох

3.1.1. Иргэд, байгууллагад хандаж уриалга гаргах, бүх нийтийн үйл хэрэг болгох зорилтын хүрээнд сургалт, сурталчилгаа, мэдээллээр хангах

3.1.2. Уг спортыг хөгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн орон нутгийн төсөвт тусгаж хэрэгжүүлэх

3.1.3. Аймгийн Гадаад харилцаанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хөгжүүлэх бодлого баримтлах./хөрш зэргэлдээ Буриад улсын Закаменск районы шатарчидтай уулзалт тоглолтыг хийж байх / шинээр нэмсэн/

3.1.4. Иргэд, байгууллагаас гаргасан санал санаачлагыг дэмжиж, болзолт уралдаан зарлах

3.1.5. Спортын холбоод, клуб, хичээллэгчдийг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах

3.1.6. Аймгийн шатрын холбоог сум бүрт салбар холбоодтой болгож, төрийн болон ТББ хамтран ажиллах нөхцөлийг бүрдүүлэх.

3.1.7. “Хүүхэд бүр шатарчин” уриалга гаргаж сурагчдын сэтгэлгээг төлөвшүүлэх

3.2 Материаллаг баазыг бэхжүүлж, энэ спортоор хичээллэх боломж нөхцлийг бүрдүүлэх, хичээллэгсдийн тоог нэмэгдүүлэх

3.2.1 Аймгийн бүх сумдын ерөнхий боловсролын сургуулиудын болон бие даасан шатрын спортын дугуйлангуудыг нээн ажиллуулах

3.2.2 Сумд, сургуулиуд, аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагуудыг ном сурах бичиг, техник хэрэгсэлтэй болоход дэмжлэг тусалцаа үзүүлэх.

3.2.3 Бүх сумдад шатарын спортоор хичээллэх сургалтын танхим нээн ажиллуулах

3.2.4 Аймгийн газар нутагт үйл ажиллагаа явуулж буй улсын болон хувийн эмнэлэгүүд, амралт сувиллын газрууд, аялал жуулчны баазууд, зуслангууд, сурагчдын дотуур байранд шатар бүхий өрөө тасалгаа байх, мөн сургуулиудын хүүхэд, багшийн хөгжлийн төв, багш нарын өрөөнд чөлөөт цагаа өнгөрөөх шатартай байх

3.2.5 **Орон сууц, нийтийн** байр талбайг тохижуулах, шатар тоглох боломжийг бий болгох

3.2.6 Сургалт, мэдээллийн гарын авлагаар хангах, онлайн болон ТВ-ээр тусгай сургалтыг зохион байгуулах

3.2.7 Олон талт тэмцээн уралдаанд шатрын тэмцээнийг оруулж хэвшүүлэх

3.2.8 Албан байгууллага, сум, сургууль бүр өөрсдийн сургалтанд хэрэглэгдэх шатрын орчин үеийн программтай болох

3.2.9 Шатрын ном, тогтмол хэвлэл, сэтгүүл зэргийг өргөн ашиглах боломжийг бүрдүүлэх,

3.2.10 **Монгол улсад анх удаа том шатар буюу Анхдагчдын талбайд шатрын талбай байгуулах**

3.2.11 **Булган аймагт шатар үйлдвэрлэх жижиг дунд үйлдвэрийг дэмжих замаар материаллаг баазыг бэхжүүлэх ажлыг зохион байгуулна.**

3.3 Уг спортыг хөгжүүлэх чиглэлээр сургагч багш, дасгалжуулагч, шүүгчдийг бэлтгэх замаар системтэй сургалтыг бий болгох нэвтрүүлэх

3.3.1 Жилд 2 доошгүй удаа өндөр зэрэгтэй багш дасгалжуулагчийг урьж **улиралын** хэлбэрээр сургалт дасгалжуулалтыг явуулах

3.3.2 ЕБС-ын сургалтын программд шатрын сургалтыг оруулах, тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлэх /шинээр нэмсэн/

3.3.3 Аймгийн хэмжээнд багш дасгалжуулагчдыг бэлтгэх, түүний сурч боловсрох нөхцөлийг хангах бодлого баримтлах

3.4 Уралдаан тэмцээнийг бүх шатанд зохион байгуулах, улс, олон улс, тив дэлхийн уралдаан тэмцээнд оролцох нөхцөл боломжоор хангах, урамшууллын асуудлыг шийдвэрлэх

- 3.4.1 Аймагт жил бүр улсын чанартай өндөр зэрэглэлийн шатарчдын тэмцээнийг зохион байгуулах,
- 3.4.2 Аймаг, сумын аварга шалгаруулах тэмцээнийг тогтмол зохион байгуулж хэвших
- 3.4.3 Жил бүр “шатарчин” гэр бүл, байгууллага, анги, хамт олныг шалгаруулж байх**
- 3.4.4 Аж ахуйн нэгж байгууллага, төрийн болон төрийн бус олон нийтийн байгууллагууд хамтран тэмцээн уралдаан зохион байгуулах
- 3.4.5 Уралдаан тэмцээнд шаардагдах зардлыг шийдвэрлэх
- 3.4.6 Нэрэмжит тэмцээнүүд бий болгох, тэмцээнийг хувь хүн болон бусад байгууллагатай хамтран зохион байгуулах
- 3.4.7 Олон улсын тэмцээн уралдаанд оролцох баг тамирчдыг бэлтгэх, тэмцээнд оролцуулах хөрөнгийн асуудлыг шийдвэрлэж байх
- 3.4.8 Насанд хүрэгчид, өсвөрийн шигшээ багийг сонгон авч хичээллүүлнэ
- 3.4.9 Монголын шатрын холбоотой жил бүр гэрээ байгуулан ажиллаж гэрээг дүгнэж байх, Монгол туургатны шатрын холбоо, Өсвөрийн шатрын холбоо, хөрш зэргэлдээ аймгуудын шатрын клубуудтэй хамтран ажиллах /шинээр нэмсэн/

3.5 Тэмцээн уралдаанд амжилт гаргасан тамирчин, багш дасгалжуулагч, шүүгч болон уг спортыг хөхүүлэн дэмжсэн сум, баг, албан байгууллага, хувь хүнийг урамшуулах тогтолцоог бүрүүлэх

- 3.5.1 Хөтөлбөр хэрэгжих хугацаанд шинээр спортын мастер, дэд мастер цолтон төрүүлэх, тэднийг урамшуулах
- 3.5.2 Улсын болон олон улсын шүүгчдийг бэлтгэх, Улсын болон олон улсын чанартай томоохон уралдаан тэмцээнд өсвөрийн болон өндөр амжилт үзүүлж буй тамирчдад санхүүгийн дэмжлэг үзүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- 3.5.3 Аймгийн нэр алдрыг өндөрт өргөж байсан ахмад багш дасгалжуулагч, тамирчдыг урамшуулах, алдаршуулах ажлыг жил бүр зохион байгуулах

3.6 Бүх шатны боловсролын байгууллагад шатрын спортыг системтэйгээр хөгжүүлэх

- 3.6.1 Боловсрол Шинжлэх Ухааны сайдын тушаалын дагуу ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын хөтөлбөрт орсон дагуу шатрын сургалтыг сурагчдад хичээллэх таатай орчинг бүрдүүлэх, **“Авьяас” хөтөлбөрийн хүрээнд нийтийг хамарсан болон Шавь сургалтыг хөгжүүлэх**
- 3.6.2 Цэцэрлэгийн насны хүүхдүүдэд анхан шатны мэдлэг олгох
- 3.6.3 Бага ангийн хүүхдүүдэд анхан болон дунд шатны мэдлэг олгох шатар тогтмол тоглох дадал олгох

3.6.4 Суурь болон ахлах ангийн хүүхдүүдэд шатрын гүнзгийрүүлсэн сургалтуудыг явуулж орчин үеийн программ бүхий хичээлүүдээр хангах

3.6.5 Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийг бүрэн хамруулсан болон тэдгээрийн эцэг эхчүүдийг хамарсан шатрын тэмцээнүүдийг тогтмол зохион байгуулах

3.6.6 Цэцэрлэг, бага ангийн багш нарыг сонгон авч сургагч багшийн сургалтанд хамруулах /шинээр нэмсэн/

3.6.7 Гэрийн болон шавь сургалтын хэлбэрээр амралтын улиралд буюу бусад үе сургалт явуулах

3.6.8 Шатрын гүнзгийрүүлсэн сургалттай ангийг СДСургуулийг түшиглэн байгуулах

Дөрөв. Хэрэгжүүлэх хугацаа

4.1 **2013-2016 онд хэрэгжүүлнэ.**

Тав. Хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалт

5.1 Аймгийн хөтөлбөрийн удирдлага зохион байгуулалтын хүрээнд:

5.1.1 Энэхүү хөтөлбөрийн биелэлтийг аймгийн Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг удирдлага зохион байгуулалтаар ханган Аймгийн Засаг даргын Тамгын газар үйл ажиллагаа үр дүнд хяналт тавин ажиллана.

5.1.2 Сум, сургууль, цэцэрлэг, албан байгууллага, төрийн бус болон хувийн хэвшлийн байгууллагын удирдлагууд хөтөлбөрийг тухайн орон нутагт хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөлдөө тусгах, хандивлагч, ивээн тэтгэгчийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээг зохион байгуулах

5.1.2 Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа бүх шатны байгууллагууд хариуцах асуудлуудынхаа хүрээнд шатрын өрөө тасалгаатай, гадаад орчинтой болох ажлыг хийх,

5.1.3 Бүх шатны байгууллагууд олон нийтийг хамарсан спортын үйл ажиллагаа явуулахдаа шатрын тэмцээнийг байнга явуулж байх

5.1.4 Сум сургууль, цэцэрлэг, бусад байгууллагад ажиллагсдад шатрын хичээл заах багшийг урамшуулах журам, үйл ажиллагаа явуулж байгаа клубуудийн ажлыг үнэлж дүгнэх журам, амжилт гаргасан тамирчид багш дасгалжуулагчдыг үнэлэх журам зэргийг боловсруулан гаргана./шинээр нэмсэн/

5.1 Сумдын Засаг дарга нар:

5.2.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүр орон нутгийн төсөвт тусгах

5.2.2 Сум орон нутагтаа шатрын клубүүдийг албан ёсоор байгуулж шатар сонирхогчдыг дэмжиж ажиллах

5.2.3 Аймгийн Засаг дарга Сумын Засаг дарга, Агентлагийн дарга нартай жил бүр байгуулах гэрээнд Шатар хөтөлбөрийн жил бүрийн ажлын талаар тусгаж байх /шинээр нэмсэн/

5.2.4 Шатар сонирхогч олон нийтийг хамруулах, **ахмад болон гэрийн ажилтай иргэд,** тэдний дулааны улиралд гадна цэвэр агаарт тоглох нөхцөл бололцоог хангах

- 5.2.5 Сар бүр буюу улирал тутам шатрын уралдаан тэмцээнийг тогтмол явуулж байх,
- 5.2.6 Бооцоот болон бусад урамшуулалтай тоглолтуудыг иргэдийн саналаар хоорондоо болон бусад сум хөрш зэргэлдээ газруудтай тоглолтыг хийхийг дэмжиж байх /шинээр нэмсэн/
- 5.2.7 Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг тухайн нутаг дэвсгэрийн хэмжээнд удирдан зохион байгуулж, үр дүнгийн тухай тайланг жил бүрийн 12 сарын 01-ний дотор аймгийн ЗДТГазрын холбогдох хэлтэст хүргүүлэх

5.3 Сургууль цэцэрлэгийн захирал, эрхлэгч нар:

- 5.3.1 Сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд шатрын спортыг хөгжүүлэх байгууллагын хөтөлбөр гарган жил бүр үр дүнг тооцож ажиллах
- 5.3.2 Шатрын уралдаан тэмцээнд оролцох баг тамирчдын бэлтгэл сургалт, уралдаан тэмцээнд оролцох хугацааны нөхцлийг бүрдүүлэх
- 5.3.3 Шатрын спортын нэрэмжит болон аварга шалгаруулах тэмцээнүүдийг уламжлал болгон сар бүр зохион байгуулж хэвших
- 5.3.4 Шатрын хичээл заадаг багшийн цалин урамшууллыг Аймгийн Засаг даргын гаргасан хууль эрх зүйн хүрээнд шийдвэрлэх /шинээр нэмсэн/

5.4 Аж ахуйн нэгж байгууллага, хувийн хэвшил, төрийн болон төрийн бус байгууллагын дарга эрхлэгч нар

- 5.4.1 Ажилчдынхаа чөлөөт цагийг өнгөрөөх шатрын өрөө тасалгаатай болох, тохижуулах ажлыг зохион байгуулах
- 5.4.2 Байгууллагынхаа ажилчдын дунд болон олон нийтийг хамарсан янз бүрийн хэлбэрийн тоглолтуудыг сар бүр зохион байгуулах
- 5.4.3 Шатрын холбогдолтой ном товхимол, сэтгүүл, гарын авлага материалаар хангах ажлыг зохион байгуулах
- 5.4.4 Нийт ажиллагсдаас тэмцээн уралдаанд оролцож байгаа тамирчдыг бүхий л талаар дэмжиж ажиллах

Зургаа. Хөтөлбөрийн хяналт шинжилгээ үнэлгээ

- 6.1.1 Хөтөлбөрийг жил бүр үр дүнг тооцон тайланг холбогдох газруудад ирүүлнэ.
- 6.1.2 Хөтөлбөрт 2 жил тутамд буюу 2014 он, 2016 онд аймгийн Засаг даргын байгуулсан ажлын хэсэг хяналт үнэлгээ шинжилгээг хийж үр дүнг ИТХ-ын Тэргүүлэгчдэд тайлагнана. /шинээр нэмж оруулсан/

Долоо. Хөтөлбөрийн санхүүжилт хүрэх үр дүн

6.1 Хөтөлбөрийг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийг дараах эх үүсвэрээс бүрдүүлнэ.

- 7.1.1 Аймгийн төсвийн хөрөнгө
- 7.1.2 Сумын төсвийн хөрөнгө
- 7.1.3 Байгууллагын үйл ажиллагааны хөрөнгө
- 7.1.4 Олон улсын байгууллага, Хандивлагч байгууллага, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллага
- 7.1.5 Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт
- 7.1.6 “Авьяас” хөтөлбөрийн санхүүжилт
- 7.1.7 Бусад

7.2 Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлсний үр дүнд 2016 онд дараах түвшинд хүрсэн байна.

7.2.1 Булган аймагт өсвөрийн болон насанд хүрэгчдийн шигшээ баг байгуулагдсан байна.

7.2.2 Бүх сумдад шатрын клуб, сонирхогчдын нэгдэл бий болж хичээлэгчдийн тоо нэмэгдсэн байна.

7.2.3 Бүх шатны сургуулиудад шатрын хичээл ордог, шатрын ном товхимол, гарын авлагаар хангагдсан байх.

7.2.4 Сум сургууль бүр орчин үеийн шатрын компьютерийн программтай болж бүх сум 1-2 сургагч багштай болно.

7.2.5 Байгууллага болгон өөрсдийн хэрэгцээний ном товхимол, шатар, шатрын танхимтай болно.

7.2.6 Жил бүр аймагтаа улс, бүс, аймгийн хэмжээний өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчид, ахмадын уралдаан тэмцээнийг зохион байгуулан уламжлал болсон байна.

7.2.7 Улсын шүүгчтэй болж шигшээ багийн тамирчдын урамшуулал болон амжилт гаргасан тамирчид жил бүр урамшуулал авдаг болно.

7.2.8 2016 онд 1000 шатарчдын баярыг зохион байгуулна

Хөтөлбөрийн хэрэгжилтийг дараах шалгуур үзүүлэлтээр үнэлнэ

№	Шалгуур үзүүлэлт	2012 оны түвшин	Хүрэх үр дүн			
			2013	2014	2015	2016
1	Шатрын спортоор хичээлэгчдийн хувь	8	15	22	29	32
2	Шатрын клубийн тоо	1	18	19	21	24
3	Шатрын хичээл ордог, сургалт явуулдаг сургуулийн тоо	1	20	20	20	20
4	Шатрын анхан шатны мэдлэг олгох, хүүхдүүд хичээллэх сургуулийн тоо	0	7	24	24	24
5	Шатрын хичээл заах сургагч багшийн тоо	3	20	23	26	30
6	Шатрын дасгалжуулагчийн тоо	3	18	19	21	24
7	Шатрын спортын шүүгчийн тоо	1	3	4	6	10
8	Аймагт зохион байгуулж байгаа нэрэмжит тэмцээн	6	10	13	16	20
9	Өсвөрийн шигшээ баг эмэгтэй	0	1	16	20	24
10	Өсөврийн шигшээ баг эрэгтэй	0	1	16	20	24
11	Насанд хүрэгчдийн шигшээ баг	0	1	8	16	16
12	Аймагт зохион байгуулах улсын чанартай уралдаан тэмцээн	0	1	2	2	2
13	Улс, бүс, олон улсын тэмцээнд оролцогчдын тоо	6	12	22	32	42
14	Тив, дэлхийн аварга шалгаруулах тэмцээнд оролцох эрх авсан тамирчдын тоо	0	1	2	3	4
15	Шатрын спортод зарцуулж буй хөрөнгө/сая төгрөгөөр/	4.0	15.0	20.0	30.0	35.0
16	Шатрын спортын мастер, дэд	6	6	7	8	10

	мастер					
17	Шатрын спортын зэрэгтэй тамирчид	20	30	45	65	90
18	Хичээллэгч хүүхдүүдийн тоо	849	1500	2200	2800	3100